БАТЛАВ

СУМЫН ЗАСАГ ДАРГА

В.САЙНБИЛЭГ

2026 оны 03 дугаар сарын 26

ХЯРГАС СУМЫН НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ГУДАМЖ, ЗАМ, ТАЛБАЙГ КАМЕРЖУУЛАХ, СУУРИЛУУЛАГДСАН КАМЕРЖУУЛАЛТЫГ "ТЕЛЕ КАМЕРИЙН ХЯНАЛТЫН ДЭД ТӨВ"-Д ХОЛБОХ ШААРДЛАГА, АШИГЛАГДАХ ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Нэг. ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ

1.1. Техникийн үндсэн нөхцөл:

1.1.1. Теле хяналтын системийн нэгдсэн удирдлага, хяналт болон системийн технологийн шийдэл, өргөтгөл суурилуулалтыг техникийн тодорхойлолтын дагуу суурилуулах бөгөөд зөрчсөн тохиолдолд ажлын гүйцэтгэлийг хүлээн авахгүй болно.

1.1.2. Техникийн нөхцөлийн дагуу угсралт, суурилуулалтын ажлыг график хуваарийн дагуу гүйцэтгэж захиалагч байгууллагад актаар хүлээлгэн өгөөгүй тохиолдолд теле хяналтын системийн гэмтэл саатал, доголдлоос үүдэн гарах зардал болон хариуцлагыг Увс аймгийн "Теле камерын хяналтын дэд төв", сумын худалдан авах ажиллагаа хариуцсан нэгж хариуцахгүй болно.

1.1.3. Шилэн кабелийн дэд бүтцийн ажлыг Харилцаа холбооны зохицуулах хорооноос олгосон "Кабель шугамын угсралт суурилуулалт хийх" тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжээр гүйцэтгүүлэх ба худаг сувагчлал, холбооны багана ашиглан гүйцэтгэх тохиолдолд "Мэдээлэл холбооны сүлжээ" төрийн өмчит компаниар техникийн нөхцөл гаргуулах, гэрэлтүүлгийн багана ашиглах бол нутгийн захиргааны байгууллагаас холбогдох зөвшөөрлийг авсан байна.

1.1.4. Цахилгаан тэжээлийн холболтыг гүйцэтгүүлэхдээ холбогдох байгууллагаас зөвшөөрөл авч, гүйцэтгүүлнэ.

1.2. Мөрдөх стандарт,шаардлага, журам:

1.2.1. Монгол Улсын стандарт MNS6423:2019 "Теле хяналтын системийн техникийн ерөнхий шаардлага"-ыг хангасан байна.

1.2.1. Шилэн кабелын MNS5207:2011, MNS5276:2013, MNS5277:2003, MNS5278:2012, MNS5280:2003, MNS5281:2003, MNS5317:2011, MNS6544:2015, MNS6597:2016 стандартуудыг хангасан байна.

1.3. Ажил хүлээж авахад бүрдүүлэх материал:

1.3.1. Ажил гүйцэтгэлийн зураг;

1.3.2. Ажлын гүйцэтгэлийн тайлан /ил, далд ажлын зурагтай/;

1.3.3. Шилэн кабелын техникийн акт;

1.3.4. Тоног төхөөрөмжийн жагсаалт, үзүүлэлт, гарын авлага;

1.3.5. Шилэн кабелын дамжуулалт, холболтын зураг /Google earth программ дээр KMZ өргөтгөлөөр, тоног төхөөрөмжийн мэдээллийн хамт/;

1.3.6. Цахилгаан тэжээлийн кабелын дамжуулалт, холболтын зураг /Google earth программ дээр KMZ өргөтгөлөөр, тоног төхөөрөмжийн мэдээллийн хамт/;

1.3.7. Цэгүүдийн байршлын мэдээлэл /Google earth программ дээр KMZ өргөтгөлөөр, тоног төхөөрөмжийн мэдээллийн хамт/;

1.3.8. Ажил хүлээн авах комиссын акт;

Хоёр. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

2.1. Тоног төхөөрөмжүүд нь стандартын дагуу суурилуулагдана.

2.2. Тоног төхөөрөмжүүдийг байнгын болон найдвартай цахилгаан тэжээлийн болон сүлжээний эх үүсвэрт холбосон байна.

2.3. Систем, техник тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацаа.

- Теле хяналтын системд ашиглагдаж байгаа техник хэрэгслүүд нь 1 жил болон түүнээс дээш хугацаатай үйлдвэрлэгчийн баталгаатай байна;

2.6. Сүлжээний замчлагч болон үндсэн төхөөрөмжүүд нь мэдээллийн аюулгүй байдлыг хангасан, сүлжээний оролтуудыг хааж, нээн хязгаарлах боломжтой байна.

2.7. Хяналтын камер, тоног төхөөрөмжүүдийн сүлжээний хаягжилт /IP/-ыг Увс аймагт одоо ашиглагдаж байгаа теле хяналтын сүлжээний хаяглалтын төлөвлөлттэй уялдуулан зохион байгуулна.

2.8. Бусад:

2.8.1. Нийлүүлэгч нь нийлүүлсэн тоног төхөөрөмжийн гэмтлийг баталгаат хугацаанд бүрэн хариуцна.

2.8.2. Нийлүүлсэн тоног төхөөрөмжүүдийг захиалагчийн байранд суурилуулж 72 цаг тасралтгүй ажиллуулан шалгасны дараа хүлээлгэн өгнө.

2.8.3. Суурилуулах бүх төхөөрөмж нь 220В, 50Гц±5% хүчдэлд ажилладаг байхаар сонгоно.

2.8.4. Теле камерын болон сүлжээний тоног төхөөрөмжүүд нь 7/24/365 байнгын тасралтгүй ажиллах зориулалттай байхаар сонгоно.

2.8.5. Техникийн тодорхойлолтод заагдсан тоног төхөөрөмжийн үзүүлэлттэй дүйцэх буюу түүнээс илүү байж болно.

2.9. Олон улсын чанарын шаардлага хангасан тоног, төхөөрөмжүүд байна.

3.0 Холбох аж ахуй нэгжийн байршил, камерын цэгийн ерөнхий бүтэц, шилэн кабелийн холболтын схем

4.0 Цагдаагийн хэсгийн байрнаас сумын холбоо хооронд татагдах шилэн кабельд мэргэжлийн байгууллагаас техникийн дүгнэлт гаргуулсан байх.

5.0 Цагдаагийн хэсгийн байрнаас сумын холбоо хооронд татагдах шилэн кабельд мэргэжлийн байгууллагаас техникийн дүгнэлт гаргуулсан байх.

6.0 Сумын камерын системийг камерын хяналтын дэд төвтэй холбоход шаардлагатай "Мэдээлэл холбооны сүлжээ" ТӨХК-аас урсгал түрээслэх 1 жилийн төлбөр болон мэргэжлийн инженерүүд ажиллах зардлыг заасан тоо хэмжээнд шийдвэрлэж тооцсон байх. /Жилийн түрээсийн төлбөр 1 сая 700 мянга, мэргэжлийн инженерүүдийн ажиллах зардал 500 мянга /

ШААРДЛАГАТАЙ ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ЖАГСААЛТ

№	Тоног төхөөрөмжийн нэр	Тавигдах шаардлага, дагалдах хэрэгсэл	Тоо хэмжээ	Бараа материалын дүйцүүлсэн байдал ба зураг
1	Шилэн кабель	Air fiber 12 core /агаараар татах/	1600 метр	
2	Шилэн кабелийн тоноглол	fiber tools	29 ширхэг	
3	Жампер кабель	SC-LC single mode 1 meter	12 ширхэг	
4	Шилэн кабелийн хувиргуур модуль	SFP module 10/100TX-100 Base FX, A/B	12 ширхэг	
5	Сүлжээний салаалагч төхөөрөмж /гадна зориулалтын/	PoE 8-port + 1-Port Uplink Switch 10/100/1000	7 ширхэг	
6	Шилэн кабелын төгсгөлийн хайрцаг /хяналтын цэгт/	FDF/4/шөрмөс	7 ширхэг	
7	Цахилгааны залгуур /камерын цэгт/	PDU 32A 16 slot	7 ширхэг	
8	Цахилгааны залгуур / хяналтын төвд /	PDU 32A 16 slot	1 ширхэг	
9	Хар хоолой		6 боодол	
10	Сүлжээний кабель	STP Cat5e	2 боодол	
11	Сүлжээний толгой		2 хайрцаг	

12	Шонгын гар	Төмөр хийцлэлтэй 1,5 метр урттай цахилгааны шонд бэхлэх боломжтой	7 ширхэг	
13	Цахилгааны утас	2*25/220V, хар бүрээстэй, агаараар татах	390 метр	
14	Камерын цэгийн Төхөөрөмжийн хайрцаг	60x80, IP67, ус чийгний хамгаалалттай	7 ширхэг	
15	Чиглэлийн камер	8MP IR Vari-focal Bullet WizSense Network Camera > 8-MP 1/2.7" CMOS image sensor, low luminance, and high definition image. > Outputs max. 8 MP (3840 × 2160) @20 fps, and supports 2688 ×1520 (2688 × 1520) @25/30 fps. > H.265 codec, high compression rate, ultra-low bit rate. > Built-in IR LED, and the max. illumination distance is 60 m. > ROI, SMART H.264+/H.265+, flexible coding, applicable to various bandwidth and storage environments.	22 ширхэг	

		> Rotation mode, WDR, 3D NR, HLC, BLC, digital watermarking, applicable to various monitoring scenes. > Intelligent monitoring: Intrusion, tripwire (the two functions support the classification and accurate detection of vehicle and human). > Abnormality detection: Motion detection, video tampering, audio detection, no SD card, SD card full, SD card error, network disconnection, IP conflict, illegal access, and voltage detection. > Alarm: 1 in, 1 out (Only - ZAS supports); audio: 1 in, 1 out (Only - ZAS supports); supports max. 256 G Micro SD card; built in MIC. > 12 VDC/PoE power supply, easy for installation. > IP67, IK10 (optional) protection. > SMD Plus.		
16	шилэн кабелийн холболтын 24 портын муфт	Fiber Splice Closure 24 Core	1 ширхэг	
17	Хяналтын төвтэй холбох урсгалын 1 жилийн төлбөр	Жилээр тооцож гэрээ байгуулах	360 хоног	1 сая 700 мянган төгрөг

18	Камерын хяналтын системийг сумын холбоонд холбох ажлын зардал	“Мэдээлэл, холбооны сүлжээ”- ТӨХК-аас мэргэжлийн ажилтангууд авчирч холболт тохиргоог хийлгэх ба камержуулалтын IP хаягийг дэд төвөөс заасан хаяжилтыг хийх	Техникийн нөхцөлийг баримтлах	500 мянган төгрөгт багтаан шийдвэрлэхээр тооцох